



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/321

Мөрөн сум

Төсөвт өртөг батлах тухай

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1-2.6.6 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн ээлжит бус XIII хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" нэрлэсэн жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

3. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулах 138,500,000 (Нэг зуун гучин найман сая таван зуун мянга) төгрөгийг орон нутгийн батлагдсан төсвөөс гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар(П.Ариунбат)-т, төлөвлөгдсөн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, гүйцэтгэлийн тайлан гаргаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Ч.Ганбаатар), аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Т.Раднаабүд) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Ариунбат)-д даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022
оны 17 сарын 21 өдрийн
А/321.. захирамжийн хавсралт

**“ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ” НЭРЛЭСЭН ЖИЛИЙН ХҮРЭЭНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ, ТӨСӨВТ ӨРТӨГ**

№	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Хугацаа
1	2.6.8	Мэргэжил сонголт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох аян, хөдөлгөөн өрнүүлэх	19.5	9-р сар
2	2.6.4	“Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн” зөвлөгөөн	5.0	9-р сар
3	2.6.6	-"Намрын өнгө-Хөдөлмөрийн шим" хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг -Баялаг бүтээгч ахмад үзэсгэлэн худалдаа	5.0	9-р сард
4	2.6.3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн төв, дундын оффисыг ашиглалтад оруулах	13.0	10-р сард
5	2.6.4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн форум зохион байгуулах	10.0	10-р сард
6	2.6.4	Старт апп хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх	53.0	10-р сард
7	2.7.3, 2.6.7	Ажил олгогчдын зөвлөгөөн	11.0	10-р сард
8	2.7.2	ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн ур чадварын уралдаан "Абилимп-2022" арга хэмжээ	8.0	11-р сард
9	2.6.1	ХАБЭА, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, эрсдэлийн үнэлгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, зөвлөн туслах аян өрнүүлэх, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах	5.0	10-р сард
10	2.6.5	“Ээлтэй ажлын байр” болзолт уралдаан зарлан дүгнэх, Нэрлэсэн жилийн ажлыг сайн зохион байгуулсан сум, байгууллагад дэмжлэг	9.0	12-р сард
		Дүн	138.5 сая	